

**“Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 6 дугаар зүйлийн 6.15, 6.21-д дараах агуулга бүхий нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай.
 - 1.1. Энэхүү нөхцөл, шаардлагын 6 дугаар зүйлд “6.21 Үйлчилгээ эрхлэгч нь 18+ насны ангиллын кино, контентыг өөрийн үйлчилгээний промо сувгаар сурталчлахгүй, видео санд байршуулахдаа богино танилцуулга бүхий дүрс бичлэг (трэйллер), контентын постер зургийг хүүхэд үзэхээс сэргийлж Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.8-д заасныг баримтлан хязгаарлалт хийнэ.” гэж, 6.15 дахь хэсгийн “Үйлчилгээ эрхлэгч нь” гэсний дараа “Мэдээлэл харилцаа холбооны техникийн өрөөнд тавих шаардлага MNS 6869” гэж тус тус нэмэх.
 - 1.2. Энэхүү нөхцөл, шаардлагын 1 дүгээр зүйлийн 1.7-д “Энэхүү нөхцөл шаардлагад тусгаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, нөхцөл шаардлагаар зохицуулна.” гэснийг “Энэхүү нөхцөл, шаардлагад тусгаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, нөхцөл шаардлага, тусгай зөвшөөрлийн гэрээгээр зохицуулна.” гэж, 2 дугаар зүйлийн 2.2 “Олон суваг дамжуулах үйлчилгээг интернэтээр дамжуулан хүргэхэд үйлчилгээ эрхлэх хүрээг тодорхой бүс нутгаар хязгаарлахгүй.” гэснийг “Олон суваг дамжуулах үйлчилгээг ОТТ технологиор хүргэхэд үйлчилгээ эрхлэх хүрээг тодорхой бүс нутгаар хязгаарлахгүй.” гэж, 5.4-д “Үйлчилгээ эрхлэгч нь гадаад улсын телевизийг дамжуулахад албан ёсны эрхийг нь авсан, тухайн телевиз нь тухайн улсынхаа хуулийн дагуу зохих зөвшөөрөл, бүртгэлтэй болохыг гэрээ, эсхүл бусад эрх зүйн баримт бичгээр баталгаажуулна. Гэрээ нь албан ёсны Монгол орчуулгатай байна.” гэснийг “Үйлчилгээ эрхлэгч нь тухайн улсынхаа хуулийн дагуу зөвшөөрөлтэй гадаадын радио, телевизийг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу эрхийг авч дамжуулна.” гэж тус тус өөрчлөх.
 - 1.3 Нөхцөл, шаардлагын 1 дүгээр зүйлийн 1.4, 1.6, 3 дугаар зүйлийн 3.1, 5 дугаар зүйлийн 5.1, 5.8, 5.9 дэх хэсгийг тус тус хүчингүй болгосугай.
2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

Гарын үсэг

“ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН НӨХЦӨЛ, ШААРДЛАГА”-Д НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТАЛААР ТАНИЛЦУУЛГА

Үндэслэл, тайлбар

2025.10.27

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4-д заасан чиг үүргийн дагуу “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ыг 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 24 тоот тогтоолоор батлан гаргаж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдөр 5306 дугаартайгаар бүртгэснээр хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн болно.

Нөхцөл, шаардлагад Зөвшөөрлийн тухай хууль 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 16 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулж Захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд холбогдох хөдөлгөөнийг хийлгэн, даган мөрдөж байна.

Энэ удаа “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д хууль тогтоомжийн дагуу дараах үндэслэлүүдийн хүрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахаар төслийг боловсруулаад байна. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын хүрээнд байгуулагдсан Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор батлан гаргасан 01 тоот дүгнэлтээр зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулж байгаа захиргааны хэм хэмжээний актыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлээс хасахыг даалгажээ. Үүнтэй уялдуулан зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг агуулсан захиргааны хэм хэмжээний актуудыг хянаж, холбогдох заалтыг хүчингүй болгох арга хэмжээг авах,
- Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17-д “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно.” гэсний дагуу тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичгийг заасан заалтуудыг хүчингүй болгохоор,
- Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 “захиргааны хэм хэмжээний акт дараах шаардлагыг хангасан байна гэсэн хэсгийн 60.1.8. бусад хуулийн заалтыг давхардуулан заалгүйгээр шаардлагатай тохиолдолд эшлэл хийгдсэн байх” гэсний хүрээнд Өргөн нэвтрүүлгийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн заалттай давхацсан заалтуудыг хасахаар,
- Өнгөрсөн хугацаанд тус хороонд ирүүлсэн үзэгчийн гомдол, саналд үндэслэн хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах зорилгоор холбогдох зохицуулалтыг тусган дараах нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулан санал авахаар холбогдох төрийн байгууллага, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч болон олон нийтэд нээлттэйгээр байршуулж байна.

Хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах заалтууд

№	Нөхцөл, шаардлагын одоогийн заалт	Өөрчлөлт оруулах санал	Үндэслэл, тайлбар
	Нэг. Нийтлэг үндэслэл		
1	1.4. Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоход Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.5-д заасны дагуу сонгон шалгаруулна.	<i>Хүчингүй болгох</i> <i>/хуулийн заалттай давхацсан агуулгатай/</i>	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.5-д “энэ хуулийн 6.1.3, 6.1.6-д зааснаас бусад төрлийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийг нээлттэйгээр сонгон шалгаруулах” гэж сонгон шалгаруулалтаар олгох тусгай зөвшөөрлийн төрлийг заасан байдаг тул нөхцөл, шаардлагаас хасах.
2	1.6 Олон суваг дамжуулах үйлчилгээг хүргэх сүлжээ, технологийн төрөл, нарийвчилсан шаардлагыг нээлттэй сонгон шалгаруулалтын баримт бичигт заана.	<i>Хүчингүй болгох</i> <i>/хуулийн заалттай давхацсан агуулгатай/</i>	Сонгон шалгаруулалтын баримт бичигт Зөвшөөрлийн тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль зэрэг зөвхөн хууль тогтоомжид заасан шаардлагуудыг бичнэ.
3	1.7.Энэхүү нөхцөл шаардлагад тусгаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, нөхцөл шаардлагаар зохицуулна.	<i>Дараах байдлаар өөрчлөн найруулах:</i> 1.7.Энэхүү нөхцөл шаардлагад тусгаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, нөхцөл шаардлага, тусгай зөвшөөрлийн гэрээгээр зохицуулна.	Тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хооронд байгуулдаг тусгай зөвшөөрлийн гэрээгээр хуулийн хүрээнд зохицуулах харилцааг нэмж тусгасан.
	Хоёр. Үйлчилгээ эрхлэх хүрээ		
4	2.2. Олон суваг дамжуулах үйлчилгээг интернэтээр дамжуулан хүргэхэд үйлчилгээ эрхлэх хүрээг тодорхой бүс нутгаар хязгаарлахгүй.	<i>Дараах байдлаар өөрчлөн найруулах:</i> 2.2. Олон суваг дамжуулах үйлчилгээг ОТТ технологиор хүргэхэд үйлчилгээ эрхлэх хүрээг тодорхой бүс нутгаар хязгаарлахгүй.	Интернэтээр гэж томьёолохоор АйПиТВ үйлчилгээнд мөн хамаарах мэт ойлгогдож байгаа тул зохицуулалтын тодорхой болгосон. ОТТ технологиор олон суваг дамжуулах үйлчилгээг хүргэхэд үйлчилгээ эрхлэх хүрээг бүс нутгаар хязгаарлах боломжгүй.
	Гурав. Телевизийн үйлчилгээ эрхлэх ерөнхий нөхцөл		
5	3.1. Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр авахад дараах нөхцөлийг бүрдүүлнэ:	<i>Хүчингүй болгох</i>	Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17-д "Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм

6	3.1.1. Үйлчилгээ эрхлэх дунд хугацааны буюу 3-5 жилийн стратеги төлөвлөгөө[2] боловсруулж, баталсан байх;		хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно.", Зөвшөөрлийн зөвлөлийн дүгнэлтэд тус тус нийцүүлэв. Зөвшөөрлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгүүдэд олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэхэд бүрдүүлэх материалыг агуулгын хувьд тусгагдсан.
7	3.1.2. Стратеги төлөвлөгөөнд салбарын хөгжилд хэрхэн хувь нэмэр оруулахыг тусгасан байх ба төлөвлөгөө нь бодитой, хэмжигдэхүйц байна;		
8	3.1.3. Шаардлагатай хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн, бизнес төлөвлөгөөг тооцоо судалгаанд суурилж гаргасан байх;		
9	3.1.4. Стратеги болон бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлсэн байх;		
10	3.1.5. Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай техник тоног төхөөрөмжийг тооцож, схем зураглалыг гаргасан байх;		
11	3.1.6. Хот, суурин газрын сүлжээ байгуулах бол сүлжээний төлөвлөлт, зураглалыг газрын зураг болон хүснэгтээр гаргасан байх;		
12	3.1.7. Ашиглах тоног төхөөрөмж, төлбөр тооцооны систем, хэрэглэгчийн төхөөрөмж (set-top-box) нь холбогдох стандарт, техникийн зохицуулалт болон аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан, итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллагын тохирлын гэрчилгээтэй байх;		
13	3.1.8. Радио, телевизийн сувгуудын дууны түвшинг Европын өргөн нэвтрүүлгийн холбооноос баталсан EBU R128 зөвлөмж, үндэсний стандартад заасан үзүүлэлтийн дагуу хянаж, тохируулах техник, программ хангамжийг бүрдүүлсэн байх;		
14	3.1.9. Радио давтамж ашиглах бол нэвтрүүлэгч болон антены байршлыг тогтоож, стандарт, шаардлага хангасан программ хангамжаар тухайн газар нутгийг бүрэн хамарсан байх хамрах хүрээний урьдчилсан тооцооллыг хийсэн байх;		
15	3.1.10. Гамшгийн зарлан мэдээллийн системтэй байх.		
Тав. Радио, телевизийг дамжуулах, гэрээ байгуулахад тавих шаардлага			
16	5.1. Үйлчилгээ эрхлэгч нь Зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөлтэй радио, телевизийг тусгай	Хүчингүй болгох	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн "26.2 Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь радио, телевизийн

	зөвшөөрөлд нь заасан хамрах хүрээнд, гэрээний үндсэн дээр дамжуулна.	/Хуулийн заалттай давхацсан агуулгатай/	хөтөлбөрийг гэрээний үндсэн дээр дамжуулна." гэсэн заалттай агуулгын хувьд давхацсан.
17	5.4 Үйлчилгээ эрхлэгч нь гадаад улсын телевизийг дамжуулахад албан ёсны эрхийг нь авсан, тухайн телевиз нь тухайн улсынхаа хуулийн дагуу зохих зөвшөөрөл, бүртгэлтэй болохыг гэрээ, эсхүл бусад эрх зүйн баримт бичгээр баталгаажуулна. Гэрээ нь албан ёсны Монгол орчуулгатай байна.	<i>Дараах байдлаар өөрчлөн найруулах:</i> 5.4. Үйлчилгээ эрхлэгч нь тухайн улсынхаа хуулийн дагуу зөвшөөрөлтэй гадаадын радио, телевизийг Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу эрхийг авч дамжуулна.	Хуулийн заалтыг давхардуулан давтахгүйгээр эшлэл байдлаар оруулж Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-д нийцүүлсэн. (Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.Гадаад улсын радио, телевизийг дамжуулахдаа албан ёсны эрхийг нь авсан, Зохицуулах хороонд бүртгүүлсэн байх бөгөөд хөтөлбөр нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, эрх ашигт харшлахгүй байна.)
18	5.8. Үйлчилгээ эрхлэгч нь дамжуулж буй гадаад улсын телевизийн хөтөлбөр дундуур аливаа хэлбэрийн зар сурталчилгаа нэвтрүүлэхгүй.	<i>Хүчингүй болгох</i> /Хуулийн заалттай давхацсан агуулгатай/	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн “24.3.Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь дамжуулж байгаа суваг, хөтөлбөр дундуур зар сурталчилгааг нэвтрүүлж үл болно.” гэсэнтэй давхацсан агуулгатай.
19	5.9. Үйлчилгээ эрхлэгч нь олон нийтийн радио болон Монгол Улсын нутаг дэвсгэрт хамрах хүрээ бүхий радиогийн хөтөлбөрийг дамжуулж болно.	<i>Хүчингүй болгох</i> /Хуулийн заалттай давхацсан агуулгатай/	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн “26.3.Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь тухайн нутаг дэвсгэрт дамжуулах тусгай зөвшөөрөлтэй радио, телевизийн хөтөлбөрийг дамжуулна.” гэсэнтэй давхацсан агуулгатай.
Зургаа. Телевизийн үйлчилгээ эрхлэх нэмэлт нөхцөл, шаардлага			
20	6.15. Үйлчилгээ эрхлэгч нь Мэдээлэл, шуудан, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчийн дуудлагын төвд тавих шаардлага стандарт MNS 6365, Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний ажилтанд тавих шаардлага MNS 5881, Мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний ажлын байранд тавих шаардлага MNS 5882 үндэсний стандартыг дотоод үйл ажиллагааны журамд тусгаж мөрдөнө.	<i>Дараах стандартын нэрийг нэмэх:</i> Мэдээлэл харилцаа холбооны техникийн өрөөнд тавих шаардлага MNS 6869	Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэхэд техник, тоног төхөөрөмжийг байршуулах техникийн өрөө шаардлагатай байдаг бөгөөд уг өрөө нь холбогдох стандартыг мөрдсөн байх шаардлагатай.
21	-	<i>Дараах хэсгийг шинээр нэмэх:</i> 6.21. Үйлчилгээ эрхлэгч нь 18+ насны ангиллын кино, контентыг өөрийн үйлчилгээний промо сувгаар сурталчлахгүй, видео санд байршуулахдаа	Тус Хороонд үзэгчдээс удаа дараа ирдэг гомдол, саналд үндэслэн энэхүү заалтыг шинээр нэмэхээр болсон. Үзэгч телевизээ асаахад олон суваг дамжуулах үйлчилгээний промо сувгаар насанд хүрэгчдэд зориулсан 18+ кино, контентын сурталчилгаа гарч байх үзэгчид таагүй мэдрэмж, айдас төрүүлдэг байна.

		богино танилцуулга бүхий дүрс бичлэг (трэйллер), контентын постер зургийг хүүхэд үзэхээс сэргийлж Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.8-д заасныг баримтлан хязгаарлалт хийнэ.	Мөн видео санд байршуулсан 18+ ангиллын киноны постер зураг, трэйллер зэргийг хүүхэд үзэхээс сэргийлж зургийг бүдгэрүүлэх, код хийж нэвтэрдэг байх зэрэг тохиргоог нэвтрүүлэх шаардлагатай гэж үзсэн.
--	--	---	---

ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ТӨСӨЛ БЭЛТГЭХ ЯВЦАД ХИЙСЭН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

/Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага/

№	Аргачлал	Асуудал	Дэлгэрэнгүй тайлбар /судалгаа байгаа бол хавсаргах/
1	Акт гаргах үндэслэл, шаардлага, зорилтыг тодорхойлох	Хуулиар тусгайлан эрх олгогдсон байх	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4 дэх заалтаар Харилцаа холбооны зохицуулах хороонд Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага батлах эрх олгогдсон. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 6 дугаар зүйлийн 6.1-д олон суваг дамжуулах үйлчилгээ нь өргөн нэвтрүүлгийн үйлчилгээнд хамаарахыг тус тус заасан.
2		Тухайн шийдвэрийг хэрэгжүүлснээр тавьсан зорилгод хүрч чадах эсэхийг тогтоох	Харилцаа холбооны зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4-д заасан чиг үүргийн дагуу “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ыг 2021 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 24 тоот тогтоолоор батлан гаргаж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдөр 5306 дугаартайгаар бүртгэснээр хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн болно. Зөвшөөрлийн тухай хууль 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлснээр “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-д тус хуульд нийцүүлэн Харилцаа холбооны зохицуулах хорооны 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 16 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулж Захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд холбогдох хөдөлгөөнийг хийлгэн, даган мөрдөж байна. Зөвшөөрлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын хүрээнд байгуулагдсан Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн өргөтгөсөн хуралдааны дүгнэлт, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсэгт нийцүүлэн хуулийн заалттай давхардсан

			хэсэг, заалтыг хүчингүй болгох болон үзэгчийн гомдол, санал үндэслэн хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах зохицуулалтыг хэрэгжүүлэх зорилт тавьсан. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийг хийснээр дээр дурдсан зорилгод хүрнэ гэж үзэж байна.
3		Зорилт нь тусгайлан эрх олгосон тухайн хуулийн агуулга, зорилго, хүрээнд нийцсэн байх	“Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ыг Харилцаа холбооны тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Радио долгионы тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуулиудад нийцүүлж боловсруулсан. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 3-6 дугаар бүлэгт заасан Харилцаа холбооны зохицуулах хорооны чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгод нийцсэн болно.
4		Актаар зохицуулах харилцааны хүрээ, хэмжээг тодорхой заах	“Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын зохицуулах харилцааны хүрээ нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтаар тодорхойлсон үйлчилгээний төрөл буюу Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9.6-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үйлчилнэ.
5	Тухайн актын ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ	Бүтцийн хувьд гарчиг, тэмдэглэх хэсэг, тогтоох хэсэг, шаардлагатай бол урьд гаргасан шийдвэрийг хүчингүй болгох тухай хэсэг болон акт хүчин төгөлдөр болох хугацааг заах	Энэхүү нөхцөл шаардлага нь Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-т “Захиргааны хэм хэмжээний актыг зөвхөн улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ.” гэж заасныг үндэслэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөж эхэлнэ.
6		Бүтцийн хувьд хэдэн бүлэг, хэдэн зүйлтэй байхыг заах	Нөхцөл шаардлага нь бүтцийн хувьд 7 зүйл, 59 хэсэг, 38 заалттай.
7	Акт батлагдсаны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийг тодорхойлох		Нөхцөл шаардлагад оруулсан өөрчлөлт батлагдсанаар олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь шууд хөндөгдөхгүй. Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн одоогийн тусгай зөвшөөрөл, эрхлэх үйл ажиллагаанд өөрчлөлт орохгүй. Уг баримт бичигт оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Харилцаа холбооны зохицуулах хорооны www.crc.gov.mn цахим хуудсаар 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрөөс 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийг хүртэл 30 хоногийн хугацаатайгаар санал авахаар байршуулж байна. Нөхцөл, шаардлагад оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Монополын эсрэг газар, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид санал авахаар хүргүүлсэн.

			Баримт бичгийн төслийг Харилцаа холбооны зохицуулах хорооны Даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Хорооны хуралдаанаар батлуулна.
8	Хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх	Хүний эрх, эрх чөлөө ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Үгүй
9		Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарласан бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Үгүй
10		Жендерийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Тийм
11		Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Үгүй
12		Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөргөдлийг бий болгох эсэх	Үгүй
13		Зах зээлд шинээр орж ирж буй аж ахуйн нэгжүүдийн хувьд бэрхшээл, хүндрэлийг бий болгох эсэх	Үгүй
14		Төрийн байгууллага болон аж ахуйн нэгж байгууллагад захиргааны шинж чанартай нэмэлт ачаалал бий болгож байгаа эсэх	Үгүй
15		Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсооход хүргэх эсэх	Үгүй
16		Эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд ямар нэгэн саад хориг тогтоох эсэх, хэрэв тийм бол тэр нь хуульд нийцсэн эсэх;	Үгүй
17		Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Үгүй
18		Хүнд суртал, авлига гарах нөхцөл, боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт байгаа эсэх, байгаа бол тэр нь хуульд нийцсэн эсэх;	Үгүй
19	Тухайн асуудлыг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хууль, захиргааны хэм хэмжээний акт гаргах эсэх	Эрх зүйн зохицуулалтын давхардал үүссэн эсэх	Үүсээгүй

20	Актыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоог хийх	Шинээр төрийн байгууллага байгуулах эсэх	Үгүй
21		Төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийгдэх эсэх	Үгүй
22		Захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Үгүй
23		Тухайн шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдон улсын төсөв болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд зардал үүсэх, эсхүл зардал бууруулах эсэх	Үгүй

--oOo--